



ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС

Хяналт шалгалтын дугаар: 2025/01

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШИН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЛИВАА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он 01 дүгээр сарын 24

ШАЛГАЛТ ХИЙСЭН НЭГЖ :	Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс
ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ :	Төлөвлөгөөт бус, хэсэгчилсэн хяналт шалгалт
ШАЛГАЛТЫН ХУГАЦАА :	2025 оны 01 дүгээр сарын 13-ний өдрөөс 01 дүгээр сарын 24-ний өдөр дуустал
ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:	Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Оюумаа
Ажлын хэсгийн ахлагч :	Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Тэмүүжин
Ажлын хэсгийн гишүүд:	Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн Ш.Дарьсүрэн Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн О.Уранчимэг Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Адъяа Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн П.Түвшинжаргал Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн А.Номундалай Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Т.Цэцэгмаа

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт:	1
1. Оршил:	2
2. Хяналт шалгалтын зорилго ба хамрах хүрээ:	2
3. Хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, ашиглалт, өөрчлөлт:	2
4. Нийслэлийн өмчийн ашиглалтгүй болон илүүдэлтэй байр талбай:	8
5. Түрээс түүнтэй холбоотой асуудлууд:	14
6. Цаашид авах арга хэмжээний санал:	18
7. Дүгнэлт:	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НИТХТ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
БЗД	Баянзүрх дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

ОРШИЛ

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/798 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь тус тушаалын хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүрэгт нийт 112 барилга байгууламжийг сонгон 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрүүдэд газар дээр нь очиж үзэн танилцаад, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллаа.

Барилга байгууламжид:

- ✓ **Баянгол дүүрэг:** 25 барилга байгууламж
- ✓ **Баянзүрх дүүрэг:** 16 барилга байгууламж
- ✓ **Сүхбаатар дүүрэг:** 21 барилга байгууламж
- ✓ **Сонгинохайрхан дүүрэг:** 15 барилга байгууламж
- ✓ **Хан-Уул дүүрэг:** 16 барилга байгууламж
- ✓ **Чингэлтэй дүүрэг:** 19 барилга байгууламжууд хамрагдсан болно.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго:

Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, ашиглалт, өөрчлөлт, захиран зарцуулалтад эрх хэмжээнийхээ хүрээнд шалгалт хийх, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, түрээсийн төлбөр төлөлгүй нийслэлийн өмчийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн хуулийн этгээдийг олж тогтоох, гэрээ байгуулахыг даалгах, байр талбайг чөлөөлүүлэх, түрээсийн төлбөрийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахад оршино.

Хамрах хүрээ:

1. Нийслэлийн өмчит төсөвт байгууллага, өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй байр талбайг тогтоох;
2. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, түрээс түүнтэй холбоотой асуудлууд.

Бүртгэлтэй барилга байгууламжийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Дүүрэг	Хуулийн этгээдийн тоо	Барилга байгууламжийн тоо
1	Баянгол	8	25
2	Баянзүрх	7	16
3	Сүхбаатар	8	21
4	Сонгинохайрхан	5	15
5	Хан-Уул	10	16
6	Чингэлтэй	6	19
	Нийт	44	112

1. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧИЙН ЭЗЭМШИЛТ, АШИГЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ:

Төлөвлөсөн нийт 112 барилга байгууламж нь нийслэлийн 44 байгууллагын балансад бүртгэлтэй бөгөөд байр талбайн эзэмшил, ашиглалтын байдлыг газар дээр

нь очиж үзэхэд дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн баланс дахь барилга байгууламж, байр талбайг бусдад эзэмшүүлж, ашиглуулахдаа манай газарт мэдэгдээгүй, өөрсдөө гэрээ байгуулан түрээс авдаг, бусдад давуу эрх олгон үйл ажиллагаа эрхлүүлсэн, мөн байгууллагуудад банкны АТМ, Киоск, Ундаа, усны автомат машинуудыг байршуулсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тогтоолын хавсралтын 9-д “Төрийн өөрийн өмчийн байр талбайд түрээслэгчийн салган зөөвөрлөх боломжтой хөрөнгө (бэлэн мөнгөний автомат машин, ундааны машин, антен, тоног төхөөрөмж, кабель, зар суртчилгаа гэх мэт)-ийг суурилуулах, байршуулах, байрлуулах төлбөрийн хэмжээг ижил төрлийн түрээсийн зах зээлийн үнийг харгалзан түрээслүүлэгч тогтоож, гэрээнд тусган баталгаажуулна” гэж заасныг, НИТХТ-ийн 2019 онд 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам” болон байгууллагуудын Өмч эзэмшлийн гэрээг зөрчөөд байна.

Мөн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын сүүлд ашиглалтад орсон барилгууд нь өрөө тасалгаа уужим саруул байсан бөгөөд зарим нэг байгууллагуудын албан хаагчид тус бүр бүтэн өрөөнд сууж байсан бөгөөд эрхэлсэн ажил үүргийн дагуу хамтад нь шахаж байршуулах боломжтой гэж үзлээ.

Хяналтаар явсан барилга байгууламж, байр талбайн ерөнхий байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжын нэр	Тайлбар						
			Байршил	Нийт талбай м2	Ашиглалтад орсон огноо	Давхар	Түрээстэй эсэх	Сул чөлөөтэй байр	Тайлбар
Баянгол дүүрэг	БГД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал	Нутгийн удирдлагын ордон 7 давхар	БГД-ийн 4-р хороо төмөр замчдын гудамж	2688	2015-12-29	7	үгүй	тийм	Өрөөнүүдийг шахаж болохоор 1-д давхарт Улсын цэцэрлэгийн салбар үйл ажиллагаа явуулдаг гэв.
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Засаг даргын Тамгын газрын конторийн барилга /үндсэн байр/	Баянгол дүүргийн 4-р хороо Замчдын гудамж	1418	1955-05-23	3	тийм	үгүй	Хаан банкны бэлэн мөнгөний машин түрээсийн гэрээтэй, өөрсдөө шууд гэрээ байгуулсан. НӨХГ-тэй гэрээгүй.
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	4-р хорооны хуучин байр /орон сууц/	4-р хорооны хуучин байр /орон сууц/	70.87	2005-12-04	1	үгүй	үгүй	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих газар буюу бизнес эрхлэгч нарыг бойжуулах төв
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Чийрэгжүүлэлтийн 4-р бүс байр /орон сууц/	чийрэгжүүлэлтийн 4-р бүс байр /орон сууц/	153.39	2007-12-30	2	үгүй	үгүй	
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	9-р хорооны хуучин байр /орон сууц/	9-р хорооны байр /орон сууц/	161.98	2010-12-30	1	тийм	үгүй	Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газрын харьяа таван толгой түлш байрлан ажиллаж байна. Өөрсдөө шууд гэрээ байгуулсан. 3 талт гэрээ байгуулах саналтай.
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Тамгын газрын 1-р өргөтгөл	Баянгол дүүрэг 4-р хороо Замчдын гудамж	566.25	2010-12-30	2	үгүй	үгүй	
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	18-р хорооны хуучин байр /орон сууц/	18-р хороо 4 хороолол 70 дугаар сургуулийн зүүн урд 1 орц 49-1 тоот	70.73	1981-01-21	1	үгүй	үгүй	Захиргааны хэргийн анхан болон дунд шатны шүүхийн шийдвэрээр иргэний өмчлөлд шийдвэрлэсэн. Дүүргийн балансаас хасуулах ажил хийгдэж байна.
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	23-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	23-р хороо Хорооны цогцолборын урд хашаанд	124	2007-12-31	2	үгүй	тийм	Сул талбайтай өвдэрхий,
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	10-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	10-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	155.5	2010-01-01	2	үгүй	тийм	сул байр талбай. Хоосон ашиглах боломжтой барилга
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	23-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	23-р хороо Хорооны цогцолборын урд хашаанд	80.3	2001-01-01	1	тийм	үгүй	ЖДҮ эрхлэгч иргэн ажилладаг.
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	23-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	23-р хороо Хорооны цогцолборын урд хашаанд	82.5	2007-01-01	1	үгүй	тийм	Сул талбайтай өвдэрхий.

	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Тамгын газрын 2-р өргөтгөлийн барилга 6 давхар	Тамгын газрын 2-р өргөтгөлийн барилга 6 давхар	948	2017-12-30	6	үгүй	үгүй	
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Ахмад хөгжлийн төвийн барилга	6 дугаар хороо Гэр бүл ёслолын ордны хажуу талд	527.25	2020-03-30	2	Үгүй	Үгүй	Зоорийн давхартай
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	Тамгын газрын сүүлийн өргөтгөл	Баянгол дүүрэг Засаг даргын Тамгын газар	2065.3	2020-03-30	7	үгүй	үгүй	
	БГД-ийн Засаг даргын Тамгын газар	18 -р хорооны конторын барилга	18-р хороо 42-р байрны зүүн талд мөсөн ктокны урд талд ХД-н 45 байрны 1 давхарт	70	2010-12-31	2	үгүй	үгүй	
	Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар	Барилга 2 хэлтэс	бгд 20 хороо	1296	2016-01-01	3	үгүй	тийм	Үйл ажиллагаа явуулах боломжгүй шатсан
	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Ахмад хүүхдийн 120 ортой эмнэлэг амбулатори	Баянгол дүүрэг 19-р хороо	2400	2017-12-26	8	Тийм	Үгүй	Үүдэндээ АТМ гэрээгүй байсан
	БГД-ийн Эрүүл мэндийн төв	БГЭМН-ийн харьяа хүүхдийн эмнэлэг	Баянгол дүүрэг 17-р хороо	2752	1989-12-30	4	Тийм	Үгүй	3 талт гэрээтэй
	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Барилга эрүүл мэндийн шинэ төв	18-р хороо, 46-р сургуулийн хажууд	9947.72	2015-12-29	9	Тийм	Үгүй	3 талт гэрээтэй
	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	11-р хорооны барилга	130.2	2001-01-01	1	тийм	үгүй	ЖДУ-ийг дэмжих төвийн дэргэдэх төв түрээсийн гэрээ байхгүй.
	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Барилга/амбулт орийн/ Эмүжин	Баянгол дүүрэг 8-р хороо	916.75	2014-12-29	4	үгүй	үгүй	
	БГД-ийн Хүүхэд залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ	Хүүхэд, залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ -ын барилга	4-р хороо, төмөр замын 41 дүгээр байрны баруун талд	2488	2015-12-30	5	Тийм	Үгүй	Өөрсдөө өдөр өнжүүлэх түрээслүүлдэг бөгөөд өрөөнүүд маш том талбайтай байсан.
	БГД-ийн Гэр бүл, ёслолын ордон ОНӨТҮГ	Гэр бүл ёслолын ордон	6-р хороо, 10-р хороолол 43-р сургуулийн хойно далан дээр	1350	2016-06-30	4	Тийм	Үгүй	1-р давхарт кофе шоп гэрээ байхгүй 3 талт
	БГД-ийн Усан спорт сургалтын төв ОНӨТҮГ	Баянгол дүүрэг Усан спорт сургалтын төв	7-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж 0 тоот өөрийн байр	956	2013-05-19	1	үгүй	үгүй	
	Баянгол дүүргийн биеийн тамир спортын хороо	Баянгол дүүргийн биеийн тамир спортын хороо				4	тийм	үгүй	Монголын усан спортын клуб, иргэн Баярхүү нар 3 талт түрээсийн гэрээтэй. Ундааны автомат машин өөрсдөө шууд түрээсийн гэрээтэй. Дүүргийн гэр бүл залуучуудын хэлтэс 6 өрөө, Дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 1 өрөө
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн Соёлын Ордон	Соёлын Ордон	жанжны гудамж ботаникийн хүрээлэн 12 хороо соёлын төв	8482.41	2014-10-30	3	Тийм	Үгүй	1-р давхарт кофе шоп, буланд буфет байсан, хурдангийн төхөөрөмж
	БЗД-ийн Эрүүл мэндийн төв	Нэгдлийн барилга	22-р хороо Энэрэл эмнэлгийн баруун талд	2318.58	1982-01-01	2	тийм	үгүй	Эмийн сан НӨХГ-тай түрээсийн гэрээтэй, 1 лавлагааны машин НӨХГ-тэй гэрээгүй
	БЗД-ийн Эрүүл мэндийн төв	Захиргааны шинэ барилга	15 хороолол 97-р сургуулийн баруун урд	1833	2024-01-02	4	үгүй	үгүй	
	БЗД-ийн Эрүүл мэндийн төв	Амбулатори 1 өргөтгөл	15 хороолол 97-р сургуулийн баруун урд	228	2020-06-08	2	үгүй	үгүй	Шинэ захиргааны барилга
	БЗД-ийн Эрүүл мэндийн төв	Дарь-Эх нэгдсэн эмнэлгийн барилга	127-р сургуулийн зүүн хойд талд	3550.7	2021-11-21	4	үгүй	үгүй	Хурдан лавлагааны машин, болон 12м2 талбайд өрөө ашиглан улсын бүртгэлийн лавлагааг гаргадаг түрээсийн гэрээ байхгүй.
	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	Төр захиргааны ордон	13-р хороо ЭТӨЧ 55-р сургуулийн хойд талд өөрийн байранд	3969.8	2011-08-31	3	тийм	үгүй	
	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	27-р хороо, Иргэдэд үйлчлэх барилга	27-р хороо, Дунд Дарь Эхийн хуучин эцсийн буудлын зүүн талд	606.72	2022-06-30	2	тийм	үгүй	2 лавлагааны машин НӨХГ гэрээгүй

	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	26-р хороо, Туул голын хойд эрэг дагуу, Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэл, Кофе шолын барилга 24м2	26-р хороо, Туул голын хойд эрэг дагуу, Маршалын гүүрний зүүн талд	24	2022-08-31	1	үгүй	үгүй	
	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	26-р хороо, Туул голын хойно, Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэл, Кофе шолын барилга 12м2-1	26-р хороо, Туул голын хойд эрэг дагуу, Маршалын гүүрний зүүн талд	12	2022-08-31	1	үгүй	үгүй	
	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	26-р хороо, Туул голын хойно Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэл, Нийтийн бие засах газрын барилга	26-р хороо, Туул голын хойд эрэг дагуу, Маршалын гүүрний зүүн талд	54	2022-08-31	1	үгүй	үгүй	
	БЗД-ийн Засаг даргын Тамгын газар	26-р хороо, Туул голын хойно, Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр, Кофе шолын барилга 12м2-2	26-р хороо, Туул голын хойд эрэг дагуу, Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэл,	12	2022-08-31	1	үгүй	үгүй	
	БЗД-ийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Баянзүрх нэг зүрх төв	ЖДҮД Баянзүрх нэг зүрх Төвийн барилга	Энхтайваны өргөн чөлөө , 22-р автобаазын урд талд	576	2012-06-30	2	үгүй	үгүй	
	БЗД-ийн Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	Ажилчдын байр	Баянзүрх дүүрэг 14-р хороо Жуковын өргөн чөлөө өөрийн байр	66	2011-12-31	1	үгүй	үгүй	
	БЗД-ийн Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	Төв оффисын барилга	Баянзүрх дүүрэг 14-р хороо Жуковын өргөн чөлөө өөрийн байр	607	1960-10-07	2	үгүй	үгүй	Өөрсдөө үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд хажуу талд 1 давхар эвдэрсэн байрууд мөн 2 давхар байр байсан бөгөөд түүнд манаач айл байсан./бүртгэлд нь байхгүй мөн оруулаагүй
	БЗД-ийн Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	Ажилчдын цайны газар	14-р хороо Жуковын өргөн чөлөө өөрийн байр	96	2018-12-31	1	үгүй	үгүй	1 давхар түгжээтэй байсан
	БЗД-ийн Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ	Баянзүрх дүүргийн усан спорт сургалтын төв	Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо, 21 дүгээр сургуулийн хойд талд	981.05	2012-09-09	1	үгүй	үгүй	
Сонгохуйрхан дүүрэг	СХД-ийн Засаг даргын Тамгын газар	Номын сангийн барилга /2-р хороо/	2-р хороо	120	2021-10-24	1			89683838
	СХД-ийн Засаг даргын Тамгын газар	16-р хорооны барилга .166.8м2.	1-р хороолол, 27-р байр 4-107 тоот	166.8	2013-03-30	1	үгүй	үгүй	
	СХД-ийн Засаг даргын Тамгын газар	Ахмадын өргөөний барилга	Буманэлзий хорооллын хажууд	543.84	2021-12-31	2	үгүй	үгүй	Ахмадуудад зохиулсан үйл ажиллагаа явуулдаг /Өрөөнүүд том/
	СХД-ийн Засаг даргын Тамгын газар	Нутгийн захиргааны нэгдсэн байр	Дүүргийн байрны хажууд	3763.2	2022-09-15	9	тийм	үгүй	Улаанзагалмайн хороо 1 өрөөнд байрлаж байсан гэрээгүй. Хур-дан-1ш, ХАС АТМ-1ш, УБГ-ын автомат машин-1ш
	СХД-ийн Биеийн тамир спортын хороо	Спорт цогцолборын барилга	34-р хороо Орбит тойрог	4200	2017-07-02	4	үгүй	үгүй	
	СХД-ийн Нэгдсэн эмнэлэг	Эмнэлгийн барилга	19-р хороо ҮЭ-ийн гудамж	3565.1	1981-12-31	3	үгүй	үгүй	ажилчдын хүүхдийн улсын цэцэрлэгийн салбар
	СХД-ийн Нэгдсэн эмнэлэг	ШИНЭ ЭМНЭЛГИЙН БАРИЛГА	19-р хороо ҮЭ-ийн гудамж	200	2022-08-30	4	тийм	үгүй	Кофе шоф, Эмийн сан, цайны газар гэсэн 3 түрээслэгчтэй.
	СХД-ийн Нэгдсэн эмнэлэг	ЭМНЭЛГИЙН ГАЗЫН БАРИЛГА	19-р хороо ҮЭ-ийн гудамж	48	2022-08-30	1	үгүй	үгүй	
	СХД-ийн Эрүүл мэндийн төв	ЭМН-н 4 давхар эмнэлэг	СХДүүрэг 13 хороо	2990	1986-12-31	4	тийм	үгүй	Худалдаа хөгжлийн банкны АТМ НӨХГ-тэй гэрээгүй.
	СХД-ийн Эрүүл мэндийн төв	1-р амб 2 давхар эмнэлэг	СХДүүрэг 19 хороо	1008	1982-08-30	2	үгүй	үгүй	
СХД-ийн Эрүүл мэндийн төв	2-р амбулаторын 2 давхар эмнэлэг	Баянгол дүүрэг 20 хороо	785.3	1978-10-31	2	тийм	үгүй	дэлгүүр, эмийн сан 3 талт гэрээтэй	

	СХД-ийн Эрүүл мэндийн төв	3-р амбулаторын 3 давхар эмнэлэг	СХДүүрэг 09 хороо баянхушуу эцэс	3786	1995-11-30	3	тийм	үгүй	Хоолны түрээсийн гэрээтэй. НӨХГ-тай
	СХД-ийн Эрүүл мэндийн төв	1 давхар хүүхдийн хэсгийн байр/ эмнэлэг	СХДүүргийн дүүрэг 02 хороо	98	1974-12-29	1	тийм	үгүй	Хуучин албан хаагчид орон сууц болгож ашигладаг
	СХД-ийн Эрүүл мэндийн төв	Улаан булан 2-р амбулаторийн агуулах	Баянгол дүүрэг 20 хороо	40	1978-11-01	1	үгүй	үгүй	
	СХД-ийн Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ	Төвийн барилга	СХД 17-р хороо өөрийн байр	1013.33	2015-12-30	1	үгүй	үгүй	
Хан-уул дүүрэг	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	Иргэдэд үйлчлэх төв байр	Чингисийн өргөн чөлөө өөрийн байр	6327.1	2015-03-25	10	Тийм	үгүй	1 киоск машин байрлуулсан гэрээгүй
	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	Татварын байр	Иргэдэд үйлчлэх төв байрны баруун талд	871.3	1965-07-02	2	Үгүй	Үгүй	2 киоск машин түрээсийн гэрээгүй , 5,8,9 давхарт 3 өрөө сул
	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	8-р хорооны ахмадын байр	8-р хорооны хойд талд	114.8	1967-08-15	1	үгүй	үгүй	
	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	15 хорооны ахмад хөгжлийн байр (Орон сууц)	хурд хороолол 4-6 тоот	62.73	2010-10-25	12	үгүй	үгүй	
	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	17 хорооны ахмадын байр (Орон сууц)	Богдын өндөр хотхон 71-2	71.32	2009-08-25	10	үгүй	үгүй	
	ХУД-ын Засаг даргын Тамгын газар	24 хорооны төрийн үйлчилгээний байр	Худ 24 хороо Вива сити хороолол	1	2022-08-26	5	үгүй	үгүй	
	ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг	Эмнэлгийн барилга	Арцатын 18 задгай	6912	1980-09-01	3	тийм	үгүй	НӨХГ-тай 2 түрээсийн гэрээтэй. Шууд гэрээтэй 2 бэлэн мөнгөний машин НӨХГ-тай гэрээгүй байна. Түрээсийн өр 1 байгууллагын 4.9 сая төгрөг байна.
	ХУД-ийн Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төвийн барилга-1	Чингисийн өргөн чөлөө	6552	1989-10-01	4	тийм	үгүй	Өвчтөний гал тогоо Гэрээ сунгахгүй талаар НӨХГ-т албан бичиг ирүүлсэн. -Enjoy кофе-ны машин гэрээгүй
	ХУД-ын Цагдаагийн 1-р хэлтэс	Цагдаагийн хэлтсийн байр	ХУД-ын ЗДТГ-ын баруун талд	1050		3	үгүй	үгүй	Magic store-ундааны машин
	ХУД-ын Ахмадын байр	Ахмадын өргөөний барилга	ХУД-ын 8-р хороо Оргил супермаркет ын баруун талд				үгүй	тийм	Сул талбай байсан. Шалгалтаар очиход цоожтой байсан
	ХУД-ийн Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төвийн Яармаг салбарын барилга	Яармагийн 1-р буудал	2220	1989-01-01	2	үгүй	үгүй	
	ХУД-ийн Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төвийн Нисэх салбарын байр	Нисэх	230	1956-01-01	1	үгүй	үгүй	
	ХУД-ийн Биеийн тамир спорт хороо	Биеийн тамир спорт хорооны спорт заал	Чингисийн өргөн чөлөө	800	2004-07-15	2	үгүй	үгүй	
	ХУД-ын Соёлын ордон	Соёлын Ордон	Чингисийн өргөн чөлөө	2087.25	1936-09-30	2	үгүй	тийм	Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны хөрөнгө бураалттай байсан. Талбайн хэмжээ 40-50 м2 орчим
	ХУД-ийн Усан спорт сургалтын төв ОНӨУТҮГ	"Хан-Уул Усан спорт сургалтын төв" ОНӨУТҮГ-ын барилга	16-р хороо, Нисэхийн 7 дугаар сургуулийн хажууд	1013.3	2016-12-22	1	үгүй	үгүй	
Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ	Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ-ын барилга	Жаргалант задгай	698.56	2019-01-06	1	үгүй	үгүй		
ЧД-ийн Нийслэлийн Замын хөгжлийн газар	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	лабораторийн барилга	БГД-ийн 20-р хороо	450	2008-01-07	2	үгүй	үгүй	
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	контор улаан булангийн барилга 16 дугаар хороо	Чингэлтэй дүүрэг 16 дугаар хороо	240	1990-01-01	1	үгүй	тийм	Иргэний танхим орж ажиллах болсон тул засварын хийгдэж байгаа болно. Одоогоор сул
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	Өрхийн эмнэлэг барилга 16 дугаар хороо	Чингэлтэй дүүрэг 16 дугаар хороо	150	1990-01-02	1	үгүй	үгүй	Хуучин барилгыг засварлан ахмадын өргөө болгон засварлах төлөвлөгөөтэй байгаа гэсэн мэдээлэл өгсөн.
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	Засаг даргын Тамгын газрын А корпус	Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо	3046	2005-06-12	5	үгүй	үгүй	
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	нэг цонхны үйлчилгээний өргөтгөл барилга	Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо	499	2009-12-31	1	тийм	үгүй	1 давхарт 2 лавлагааны машин ажиллаж байна. НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй.
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	эрх зүйн тусалцааны төв	Чингэлтэй дүүрэг 7 дугаар хороо	90	2015-01-02	2	үгүй	тийм	үйл ажиллагаа явуулаагүй хорооны ахмадын хөгжлийн төв ашиглахаар төлөвлөсөн гэв.
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	улаан булан 12 дугаар хороо	Чингэлтэй дүүрэг 12 дугаар хороо	80	1999-01-01	1	үгүй	үгүй	2 лавлагаа машин байрлаж байна.

	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	Хайрхан хөгжлийн төвийн барилга 2	Чингэлтэй дүүрэг 7 дугаар хороо	590	2020-08-03	5	тийм	тийм	Өөрсдөө шууд гэрээ байгуулсан. Батбайгаль бейкери ХХК-тай, 4, 5 дугаар давхаруудад 3 өрөө сул чөлөөтэй ашиглах боломжтой гэв.
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	Хайрхан хөгжлийн төвийн барилга 1	Чингэлтэй дүүрэг 19 дүгээр хороо	550	2019-10-30	5	тийм	үгүй	Гэрээг лавлагааны машин, цайны газар түрээстэй 4 газартай НӨХГ-тай түрээсийн гэрээ байхгүй. Юнител антенн байршуулсан гэрээ байхгүй, 3 давхар барилга нийслэлийн өмчид бүртгүүлээгүй
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	12 хороо контор	Чингэлтэй дүүрэг 12 дугаар хороо	499	1999-01-01	1	үгүй	үгүй	Насан туршийн боловсролын төв үйл ажиллагаа явуулдаг.
	ЧД-ийн Засаг даргын Тамгын газар	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	Чингэлтэй дүүрэг 7 дугаар хороо	360	2020-05-22	3	Үгүй	үгүй	
	ЧД-ийн Эрүүл мэндийн төв	Амбулатори 1-н 2 давхар барилга	5-р сургуулийн зүүн талд	200	1968-03-30	2	үгүй	үгүй	
	ЧД-ийн Эрүүл мэндийн төв	Төв салбар 2		600	1939-12-31	3	үгүй	үгүй	ЭМЯ-д шилжсэн.
	ЧД-ийн Эрүүл мэндийн төв	Нэгдсэн эмнэлэг 7 давхар барилга	Чингэлтэй дүүрэг 4-р хороо Соёл урлагийн их сургуулийн замын урд талд	250	1985-01-02	7	Үгүй	үгүй	
	ЧД-ийн Эрүүл мэндийн төв	Хүүхдийн амбулатори	Чингэлтэй дүүрэг 15-р хорооны хойд талд	576	2016-05-29	2	үгүй	үгүй	
	ЧД-ийн Эрүүл мэндийн төв	Тонг төхөөрөмж байрлах барилга /2018/	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р сургуулийн зүүн талд	9	2018-04-18	1	үгүй	үгүй	
	ЧД-ийн Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв	Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв	чингэлтэй дүүргийн 280-р цэцэрлэгийн зүүн талд	2023.46	2021-09-27	3	үгүй	үгүй	
	ЧД-ийн Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв УТҮГ	Конторын барилга	124 цэцэрлэгийн баруун талд	217	1987-05-01	1	үгүй	үгүй	
	ЧД-ийн биеийн тамир спортын хороо	ЧД-ийн биеийн тамир спортын хороо	125 цэцэрлэгийн баруун талд	956	2022-0101	5	тийм	үгүй	1 цайны газар НӨХГ-тэй гэрээтэй
Сүхбаатар дүүрэг	СБД-ийн Засаг даргын Тамгын газар	ЖДҮДэмжих барилга	13-р хорооны хажууд	1182.9	2012-09-05	2	тийм	үгүй	ЖДҮ эрхлэгч нарыг байршуулж ажиллуулж байсан. Тэдгээрд түрээслэдэг.
	СБД-ийн Засаг даргын Тамгын газар	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилг	17-р хорооны хажууд	230	2013-10-31	2	үгүй	үгүй	Дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв үйл ажиллагаа явуулдаг.
	СБД-ийн Засаг даргын Тамгын газар	СБД-ийн Төр захиргааны нэгдсэн барилга	СБД 7-р хороо Денверийн гудамж	53848	2018-12-29	10	тийм	тийм	10 дугаар давхарт цайны газар ажиллаж байсан 168м2 талбай хоосон байсан. АТМ, Хур-дан-2ш, Кiosk-1ш, unicef аппарат
	СБД-ийн Эрүүл мэндийн төв	Төв поликлиникийн барилга	100 айл Цагдаагийн гудамж, өөрийн байр	6332.16	1996-12-25	4	тийм	үгүй	лавлагааны машин, ундааны машин, эмийн сан НӨХГ-тай гэрээтэй эсэхийг тодруулах
	СБД-ийн Эрүүл мэндийн төв	Салбар амбулатори 2-ын барилга	Дамбадаржаа онцгой байдлын хэлтэсийн ард	518.28	2007-06-10	2	үгүй	тийм	Шинээр баригдсан Сэлбэ нэгдсэн эмнэлэгт нүүж орсон тул хоосон байсан.
	СБД-ийн Эрүүл мэндийн төв	Сувиллын газрын барилга	Дамбадаржаа онцгой байдлын хэлтэсийн ард	1550	2015-06-27	4	үгүй	тийм	Гадна, дотор их засвар хийж байсан бөгөөд ажиллаагүй байсан.
	СБД-ийн Хүүхдийн урлан бүтээх төв	Ордны барилга	Бага тойруу	6994	2018-12-31	3	үгүй	үгүй	
	СБД-ийн Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	ЧД дэх салбар номын сан	Бага тойруу 6-р байр	438	1957-01-01	1	тийм	үгүй	АНУ-ын Соёл мэдээллийн төв, Монгол судлалын төв байрлаж байв гэрээгүй
	СБД-ийн Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	ХУД дэх салбар номын сан	Жаргалант үйлчилгээний төв	512	1974-01-01	2	үгүй	үгүй	
	СБД-ийн Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	БЗД дэх салбар номын сан	12-р хороолол 58-р байр	156	1968-01-01	1	Тийм	Үгүй	Өөрсдөө түрээсэлдэг
	СБД-ийн Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	СХД дэх салбар номын сан	Цамбагарав үйлчилгээний төв	385	1991-01-01	2	Тийм	Үгүй	Өөрсдөө түрээсэлдэг
	СБД-ийн Хүрээ амаржих газар төрөлжсөн	Төрөх барилга	Сайноёнхан Намнансүрэнгийн гудамж 3	2159	1959-12-09	2	Үгүй	тийм	Шинэ барилга ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байгааг бүртгээгүй байна. Хуучин барилга одоогоор суларч магадгүй

мэргэшлийн эмнэлэг									
СБД-ийн Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	А блок	энхтайвны өргөн чөлөө, Улаанбаатар -210648	2268	1978-06-30	2	Үгүй	үгүй		
СБД-ийн Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Б блок	энхтайвны өргөн чөлөө, Улаанбаатар -210648	6520	1981-01-31	5	Тийм	үгүй	3 талт гэрээтэй	
СБД-ын Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Барилга /өргөтгөл/	Энхтайвны өргөн чөлөө	8915	2013-06-13	6	Тийм	Үгүй	3 талт гэрээтэй	
СБД-ын Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	В блок	энхтайвны өргөн чөлөө, Улаанбаатар -210648	2277	1978-09-30	2	Үгүй	Үгүй		
СБД-ын Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Г блок	энхтайвны өргөн чөлөө, Улаанбаатар -210648	216	1978-06-30	1	Үгүй	Үгүй	1-р давхарт ус ундааны машин	
СБД-ын Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	Хүүхдийн ордоны барилга	Улаанбаатар СБД 1-р хороо Хүүхдийн ордон	10757	1984-11-15	3	тийм	үгүй	Нийт 9 түрээсийн гэрээтэй байгууллагын түрээсийн орлогын 60%-г Улаанбаатар хотын хөгжлийн корпораци төвлөрүүлдэг.	
СБД-ын Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	Улаанбаатар хотын нийтийн номын сангийн барилга	5-р хороо Улаанбаатар хотын нийтийн номын сан	5894	1980-01-01	2	тийм	Үгүй	Хөгжлийн корпорацид түрээс төлдөг	
СБД-ийн Цагдаагийн газар	СБД-ийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс	СБД-ийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс			3	үгүй	үгүй		
СБД-ийн Цагдаагийн газар	СБД-ийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс	СБД-ийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс			2	үгүй	үгүй	НЦУГ-ын эргүүл, хяналтын хэлтэс байрлаж байсан.	

2.НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТГҮЙ БОЛОН ИЛҮҮДЭЛТЭЙ БАЙР ТАЛБАЙ:

Нийт 112 барилга байгууламжаас ашиглалтгүй болон илүүдэлтэй гэж үзсэн байр талбайд тэмдэглэл хөтлөн, фото зургаар баримтжуулан ажилласан бөгөөд нийт 17 байр талбай ашиглалтгүй хоосон гэж үзлээ.

Үүнийг дүүргээр нь авч үзвэл:

- Баянгол дүүрэг- 7
- Сүхбаатар дүүрэг-4
- Чингэлтэй дүүрэг-3
- Хан-Уул дүүрэг-3

Үүнээс дурьдахад Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газруудад сул, цоожтой, ашиглалт тодорхой бус байр талбай нэлээдгүй байсан.

Дээрх хоосон, ашиглалтгүй байр талбайг хүснэгтээр дэлгэрэнгүй үзүүлбэл: Баянгол дүүрэг

Барилга байгууламжийн нэр: 23-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
Давхар: 2



Тус барилга нь 2008 онд ашиглалтад орсон 2 давхар 124,16 м2 талбайтай эвдэрч муудсан барилга, засвар хийх шаардлагатай.

Барилга байгууламжийн нэр: **23-р хорооны цагдаагийн хуучин барилга**

Давхар: 1

Дулаан халаалт байхгүй 82,5 м2 талбай бүхий хоосон, эвдэрч муудсан барилга байна.




Барилга байгууламжийн нэр: **10-р хорооны хуучин барилга**

Давхар: 2



Шинэ хорооны цогцолбор ашиглалтад орсон тул хуучин хорооны 155 м2 барилга ашиглах боломжтой.



Барилга байгууламжийн нэр: **Хорооны цагдаагийн хэлтсийн хуучин барилга**

Давхар: 1



Хорооны цагдаагийн хуучин барилга 50 м2 талбайтай 1 давхар байр. Халаалтгүй одоогоор ашиглах боломжгүй. Тус барилга нь НӨХГ-ын балансад бүртгэлтэй, газар нь БГД-ийн Цагдаагийн газрын балансад бүртгэлтэй хөрөнгө.

Барилга байгууламжийн нэр: 8-р хороо байрны 18 дугаар байр 1 давхарын байр

Давхар: 1

БГД-ын 18 дугаар байрны 1 давхарын 153 м2 талбайд ахмадын хөгжлийг дэмжих 3 дугаар төв байрладаг гэх боловч бараг ажилдаггүй ихэнх үед хаалттай байдаг гэсэн мэдээллийг дүүргээс өгсөн.




Барилга байгууламжийн нэр: 20-р хороонд Халуун усны байр

Давхар: 1




Хорооны цагдаагийн хуучин барилга 66 м2 талбайтай 1 давхар байр. Халаалтгүй одоогоор ашиглах боломжгүй. Тус барилга нь БГД-ын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй, газар нь БГД-ийн Цагдаагийн газрын балансад бүртгэлтэй хөрөнгө.



Барилга байгууламжийн нэр: 10-р хорооны халуун усны барилга

Давхар: 2



Тус халуун усны барилга нь 2 давхар 272,16 м2 талбай бүхий дотор нь үйл ажиллагаа явуулаагүй байна.


Сүхбаатар дүүрэг

Барилга байгууламжийн нэр: **Төр захиргааны нэгдсэн барилга**

Давхар: 10 дугаар давхарт



Сүхбаатар дүүргийн төр захиргааны барилгын 10 дугаар давхарт цайны газрын зориулалттай 168 м2 талбай хоосон байсан.



Барилга байгууламжийн нэр: **Эрүүл мэндийн Салбар амбулатори 2-ын барилга**

Давхар: 2



Шинээр баригдсан Сэлбэ нэгдсэн эмнэлэгт нүүж орсон тул хоосон байсан.

Барилга байгууламжийн нэр: **Сувиллын газрын барилга**

Давхар: 4

Гадна, дотор их засвар хийж байсан бөгөөд ажиллаагүй байсан. Хоосон талбайтай ашиглах боломжтой.



Барилга байгууламжийн нэр: **Хүрээ амаржих газар**

Давхар: 4

Шинэ барилга ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байгаач бүртгээгүй байна. Хуучин барилга одоогоор суларч байгаа.



Хан-Уул дүүрэг

Барилга байгууламжийн нэр: **Засаг даргын Тамгын газар Татварын байр**

Давхар: 10



Барилгын 5,8,9 давхарт 3 өрөө сул байсан.



Барилга байгууламжийн нэр: **Ахмадын өргөөний барилга**

Давхар: 1



Сул талбай 114.8 м² байсан. Шалгалтаар очиход цоожтой байсан.

Барилга байгууламжийн нэр: **Соёлын ордон**

Давхар: 2



Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны хөрөнгө хураалттай байсан. Талбайн хэмжээ 40-50 м2 орчим



Чингэлтэй дүүрэг

Барилга байгууламжийн нэр: **Контор улаан булангийн барилга 16 дугаар хороо**

Давхар: 1



Контор улаан булангийн барилга 16 дугаар хорооны барилгад засварын ажил хийгдэж байсан. Шалгалтын ажлын үеэр үйл ажиллагаа явуулаагүй байсан.

Барилга байгууламжийн нэр: **Эрх зүйн туслалцааны төв**

Давхар: 2



Үйл ажиллагаа явуулаагүй хорооны ахмадын хөгжлийн төвөөр дүүрэг ашиглахаар төлөвлөсөн. Барилгын В1 давхарт 2 машины дулаан граж, сул талбайн хэмжээ 90 м2, халаалт дулаан хэвийн.



Барилга байгууламжийн нэр: **Хайрхан хөгжлийн төвийн барилга 2**


Давхар: 4, 5



Барилгын 4, 5 дугаар давхаруудад 3 өрөө сул чөлөөтэй ашиглах боломжтой байсан.




Хоосон, ашиглалтгүй байр талбайг графикаар үзүүлбэл:



Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд илүүдэлтэй байр, талбай илрээгүй бөгөөд томоохон байр талбайтай аж ахуй нэгжийн өрөө тасалгаан зай талбайг дахин зохион байгуулах боломжтой.

Байр талбайн ашиглалтыг графикаар үзүүлбэл:



3.ТҮРЭЭС ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД:

Хяналтаар явсан 44 хуулийн этгээдийн 31 байр талбайд НӨХГ-тай гурвалсан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж холбогдох төлбөрийг өөрсдөө авч байсан зөрчил илэрсэн.

Үйл ажиллагаа явуулж байсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хүснэгтээр дэлгэрэнгүй үзүүлбэл: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Баянгол дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжийн нэр	Тайлбар
<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Засаг даргын Тамгын газар	Засаг даргын Тамгын газрын конторийн барилга /үндсэн байр/	- Хаан банкны бэлэн мөнгөний машин гэрээгүй.
2.	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал	Нутгийн удирдлагын ордон 7 давхар	- Өрөөнүүдийг шахаж болохоор 1-д давхарт Улсын цэцэрлэгийн салбар үйл ажиллагаа явуулдаг.
3.	Засаг даргын Тамгын газар	9-р хорооны хуучин байр /орон сууц/	- Таван толгой түлшний Хэрэглэгчдэд үйлчлэх төв байрлан үйл ажиллагаа явуулдаг.
4.	Засаг даргын Тамгын газар	20-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, хорооны барилга	- ЖДҮ эрхлэгч иргэн ажилладаг.
5.	Засаг даргын Тамгын газар	23-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга	- ЖДҮ эрхлэгч иргэн ажилладаг, гэрээгүй.
6.	Засаг даргын Тамгын газар	21-р хорооны халуун усны барилга	- Үйлчилгээний зориулалттай иргэд үйл ажиллагаа явуулдаг гэрээгүй.
7.	Эрүүл мэндийн төв	Ахмад хүүхдийн 120 ортой эмнэлэг амбулатори	- Голомт банкны бэлэн мөнгөний машин гэрээгүй.
8.	Эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	- Дүүргийн ЖДҮ-ийг дэмжих төв үйл ажиллагаа явуулдаг.
9.	Хүүхэд залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ	Хүүхэд, залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ-ын барилга	- Өдөр өнжүүлэх газар түрээсийн гэрээгүй.
10.	Гэр бүл, ёслолын ордон ОНӨТҮГ	Гэр бүл ёслолын ордон	- 1-р давхарт кофе шоп гэрээгүй.
11.	Биеийн тамир спортын хороо	Баянгол дүүргийн биеийн тамир спортын хороо	- Ундааны автомат машин гэрээгүй.

Баянзүрх дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжийн нэр	Тайлбар
<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Соёлын Ордон	Соёлын Ордон	- 1-р давхарт кофе шоп гэрээгүй. - Булангийн жижиг дэлгүүр гэрээгүй. - Хурдангийн төхөөрөмж гэрээгүй. - Гэрэгэ киоск машин гэрээгүй.
2.	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төв	- Ундааны автомат машин гэрээгүй. - Хурдан лавлагааны машин гэрээгүй.
3.	Эрүүл мэндийн төв	Дарь-Эх нэгдсэн эмнэлгийн барилга	- Хурдан лавлагааны машин болон 12м ² талбайд өрөө ашиглан улсын бүртгэлийн лавлагааг гаргадаг түрээсийн гэрээгүй.
4.	Засаг даргын Тамгын газар	27-р хороо, Иргэдэд үйлчлэх барилга	- Лавлагааны машин 2 гэрээгүй

Сүхбаатар дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжийн нэр	Тайлбар
---	----------------------	---------------------------	---------

<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Засаг даргын Тамгын газар	ЖДҮДэмжих барилга	- ЖДҮ эрхлэгч нарыг байршуулж ажиллуулж байсан. Тэдгээрд түрээслэдэг.
2.	Засаг даргын Тамгын газар	Төр захиргааны нэгдсэн барилга	- Худалдаа хөгжлийн банкны бэлэн мөнгөний машин гэрээгүй. - Хур-дан-2ш автомат машин гэрээгүй - Киоск-1ш автомат машин гэрээгүй
3.	СБД-ийн Эрүүл мэндийн төв	Төв поликлиникийн барилга	- Хур-дан лавлагааны машин гэрээгүй - Автомат ундааны машин гэрээгүй.
4.	Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	ХУД дэх салбар номын сан	- АНУ-ын Соёл мэдээллийн төв гэрээгүй. - Монгол судлалын төв гэрээгүй. <i>Улаанбаатар хөгжлийн корпораци</i> тэй түрээсийн гэрээтэй
5.	Өргөө амаржих газар	Г блок	- 1-р давхарт ус ундааны автомат машин гэрээгүй.

Сонгинохайрхан дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжийн нэр	Тайлбар
<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Засаг даргын Тамгын газар	Нутгийн захиргааны нэгдсэн байр	- Улаанзагалмайн хороо 1 өрөөнд байрлаж байсан гэрээгүй. - Хур-дан-1ш, - ХАС АТМ-1ш, - УБГ-ын автомат машин-1ш
2.	Нэгдсэн эмнэлэг	Эмнэлгийн хуучин барилга	- Ажилтчдын хүүхдийн улсын цэцэрлэгийн салбар гэрээгүй
3.	Эрүүл мэндийн төв 2 хороо	1 давхар хүүхдийн хэсгийн байр/ эмнэлэг	- Хуучин албан хаагчид орон сууц болгож ашигладаг гэрээгүй.
4.	Эрүүл мэндийн төв 13 хороо	ЭМН-н 4 давхар эмнэлэг	- Худалдаа хөгжлийн банкны АТМ гэрээгүй.

Хан-Уул дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга, байгууламжийн нэр	Тайлбар
<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Засаг даргын Тамгын газар	Иргэдэд үйлчлэх төв байр	- Киоск машин байрлуулсан гэрээгүй
2.	Нэгдсэн эмнэлэг	Эмнэлгийн барилга	- Худалдаа хөгжлийн банкны бэлэн мөнгөний машин 2ш гэрээгүй
3.	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төвийн барилга-1	- Enjoy кофе-ны машин гэрээгүй
4.	Цагдаагийн 1-р хэлтэс	Цагдаагийн хэлтсийн байр	- Magic store-ундааны машин гэрээгүй.

Чингэлтэй дүүрэг

№	Эзэмшигч байгууллага	Барилга, байгууламжийн нэр	Тайлбар
<i>НӨХГ-тай түрээсийн гэрээ байгуулаагүй газрууд</i>			
1.	Засаг даргын Тамгын газар	нэг цонхны үйлчилгээний өргөтгөл барилга	- 1 давхарт 2 лавлагааны машин гэрээгүй.

2.	Засаг даргын Тамгын газар	Хайрхан хөгжлийн төвийн барилга 2 ОНӨТҮГ	- Батбайгаль бейкери ХХК гэрээгүй.
3.	Засаг даргын Тамгын газар	Хайрхан хөгжлийн төвийн барилга 1 ОНӨТҮГ	- Гэрэгэ лавлагааны машин гэрээгүй. - Юнител антенг гэрээгүй - Батбайгаль бейкери ХХК гэрээгүй. - Сүүж уулын оргил цайны газар гэрээгүй.

Мөн байгууллагуудын автозамын гадна зогсоолд автомат хаалтыг байршуулсан байсан бөгөөд бүгд ямар нэг түрээсийн гэрээ байгуулаагүй байгаа нь холбогдох хууль, журмыг зөрчсөн гэж үзлээ.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлын хэсгийн зүгээс дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Хоосон байсан байр талбайд эргэн хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах /удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу;
2. Нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн гадна автомашины зогсоолд НИТХТ-ийн 65 дугаар тогтоолын дагуу 3 талт гэрээг байгуулан Нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх;
3. Бусдад давуу эрх олгон нийслэлийн өмчийн байр талбайд үйл ажиллагаа эрхлүүлж байгаа удирдлагуудад албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх;
4. НИТХТ-аар батлагдсан холбогдох журмуудыг хэрэгжүүлж ажиллах;
5. АТМ, КИОСК, ундаа усны автомат машин байршуулсан бүх байгууллагад албан бичгийг хүргүүлж түрээсийн 3 талт гэрээг байгуулах;
6. НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын биелэлтийг хангаж, илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэхээр сонгон шалгаруулалт зарлах, гэрээ байгуулаагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагатай түрээсийн гэрээг яаралтай байгуулан ажиллах;
7. Илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэх түрээсийн гэрээг ТӨБЗГ-ийн 2020 оны 119 дүгээр “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан жишиг үнийг баримтлан байгуулах, түрээсийн гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн хуулийн этгээдэд холбогдох албан бичгийг хүргүүлэх, байр талбайг чөлөөлөх, ажилласан хугацааны төлбөрийг заавал төлүүлэх;
8. Дээрх асуудалтай холбоотой байгууллагуудад зөвлөмж дүгнэлтийг хүргэх.

ДҮГНЭЛТ:

Нийслэлийн Өмчийн эд хөрөнгийн түрээс, илүүдэлтэй байр талбайн сонгон шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 80 дугаар зүйлийн “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам”-д “Орон нутгийн өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу”, мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоолоор баталсан журмуудыг тус тус үндэслэн зохион байгуулан ажиллаж, холбогдох мэдээ, мэдээлэл, дэлгэрэнгүй судалгааг тодорхой гаргах нь зүйтэй байна.

-----o0o-----